МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 02 өдөр Дугаар А/208 Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгаллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 15 дугаар зүйлийн 15.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын 15-ны А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн А/161 дугаар "Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" захирамжийн 2 дугаар хавсралтад Цагаан-Уул 10,0 мянга гэснийг 6666 гэж, 15 тн гэснийг 10 тн гэж, мөн 2 дугаарт Цэцэрлэг сум 3333 га талбайд 5 тн бактерийн будаа, 3,500,000 төгрөг гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг технологийн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг улс, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр тус тусад нь гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын Газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6711010660